

**ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр, Даваа гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

|                                          |      |
|------------------------------------------|------|
| <b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>        | 1    |
| <b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b> | 2-11 |

---

|                                                                                                                                                                                                                               |      |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|
| 1. Улсын Их Хурлын даргын 2024 оны 93 дугаар захирамжаар байгуулагдсан “Хүний эрхийг хангах үндэсний 2 дугаар хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн мэдээллийг сонсох | 2-11 |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы  
Ёс зүйн дэд хорооны  
11 дүгээр сарын 10-ны өдөр /Даваа гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Ёс зүйн дэд хорооны дарга Б.Баярбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 9 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 18 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: О.Саранчулуун;  
Чөлөөтэй: Ч.Лодойсамбуу, Ө.Шижир.

**Нэг.Ёс зүйн хариуцлага ногдуулах тухай асуудал**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, референт О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагаас 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Ёс зүйн дэд хороонд хандан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнтэй холбоотой гомдол ирүүлснийг судалсан талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн гишүүн Ч.Номин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Ж.Чинбүрэн, Д.Ганмаа нарын тавьсан асуултад Дэд хорооны дарга Б.Баярбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, О.Алтангэрэл, Ч.Номин, Д.Ганмаа, Б.Баярбаатар нар үг хэлэв.

Дэд хорооны дарга Б.Баярбаатар Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнг Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаад хандан “Уучлал хүссэн” албан бичиг явуулахыг санал болгосныг талууд харилцан зөвшөөрч, гар барин эвлэрэв.

Уг асуудлыг 12 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 33 минут үргэлжилж, 9 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр 12 цаг 51 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
ЁС ЗҮЙН ДЭД  
ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр,  
Даваа гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим  
12 цаг 18 минут.

### **ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Баярбаатар:** Ёс зүйн дэд хорооны гишүүддээ 11 сарын 10-ны өдрийн мэндийг хүргэе. Ирц хүрсэн тул өнөөдрийн хурлыг нээхэд бэлэн боллоо. Оюунсайханы Алтангэрэл гишүүн ирсэн байна, Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар ирсэн байна, Чинбатын Номин гишүүн ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна, Доржзовдын Энхтуяа гишүүн ирсэн байна. Отгоны Саранчулуун гишүүн гадаад томилолттой, Чулуунбилэгийн Лодойсамбуу болон Өлзийхүүгийн Шижир гишүүн нар чөлөө хүссэн тул өнөөдрийн хурлыг нээснийг мэдэгдье.

Хурлаар ёс зүйн хариуцлага ноогдуулах тухай гэсэн нэг л асуудлыг хэлэлцэнэ. Улсын Их Хурлын гишүүн Ганмаа гишүүнээс гарсан, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн Чинбүрэнтэй холбоотой асуудал байгаа. Энэ асуудлыг Отгоны Саранчулуун гишүүн, Доржзовдын Энхтуяа гишүүн, Чинбатын Номин гишүүн нараар бүрдүүлсэн ажлын хэсэг ажиллаад, санал, дүгнэлтээ боловсруулсан байгаа. Ингээд санал, дүгнэлтийг танилцуулна уу хэмээн Чинбатын Номин гишүүнийг урьж байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Номин гишүүн.

**Ч.Номин:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагаас 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Улсын Их Хурал, УИХ 03 11 434 тоот албан бичгээр Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороонд хандан 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн Өргөдлийн байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэнгийн гаргасан үйлдэлд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан хүний үндсэн, хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролынх нь боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21-д Улсын Их Хурлаас баталсан Гишүүний ёс зүйн дүрэм, хуралдааны дэгийг чанд сахиж ажиллах, 44 дүгээр зүйлийн 44.1.11-д бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны болон нэгдсэн хуралдаанд, эсхүл хуралдаанаас гадуур бусдыг гүтгэж доромжлох, өөрийн, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д албан үүргээ гүйцэтгэхдээ бусдыг аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх, Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.5-д биеэ авч явах шударга байдлаар үлгэрлэн дуурайлал үзүүлэх, 2.2.1-д гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс зүйн шаардлага биелүүлэх, 3 дугаар зүйлийн 3.2-т бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн, эрхэмлэж, эрхэмлэн хүндэтгэлтэй хандах, бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэх доромжлохыг цээрлэнэ, 3.5-д чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны дэг зөрчиж, хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хуралдаанд үг хэлэх, байр сууриа илэрхийлэхдээ бүдүүлэг үг хэрэглэх, хэллэг хэрэглэх, бусдын нэр төр, алдар хүндийг гутаан

доромжлохыг хориглоно, 3.17.Төрийн ёслол хүндэтгэлийн болон Төрийн ордны дэг журмыг чанд баримтлахаас гадна, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны танхимд биеэ зөв авч явах үүрэгтэй ба бусдыг ялгаварлан гадуурхах, зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн талаар гомдол ирсэн.

Дээрх асуудалтай холбогдуулан Цахиур.мн сайтын редаксаас 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 2025/24 тоот албан бичгээр нийтийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн мэдэх эрхийг хангах, мөн хяналтын үүргийн хүрээнд Ж.Чинбүрэн сайдын ёс зүйгүй үйлдлийг шалгаж, хариуцлага тооцуулах хүсэлтийг мөн ирүүлсэн болно.

Эдгээр гомдол хүсэлтийн дагуу Ёс зүйн дэд хорооны даргаас Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт гишүүний ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Байнгын хорооны дарга хүлээн авч, Байнгын хорооны аль нэг гишүүнд хянуулахаар шилжүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, Ч.Номин, Д.Энхтуяа нарт хянуулахаар хүргүүлсэн болно.

Уг асуудлаар дээр нэр дурдсан гишүүд Монгол Улсын Их Хурлын гишүүн Ёс зүйн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.4.1 дэх заалтын дагуу 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа, Ж.Чинбүрэн, Г.Лувсанжамц нартай тус тус биечлэн уулзаж тайлбар саналыг сонссон. Тайлбар саналын хувьд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаагийн өгсөн тайлбартаа 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хороогоор эмч, багш нарын цалинг нэмэх асуудлаар хэлэлцэх үеэр би асуулт асуухад Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн Байнгын хорооны хуралдааны дэг, ёс зүй зөрчиж намайг сүрдүүлсэн, сүрдүүлсэн, саад учруулах зорилготой үйлдэл хийсэн гэж үзэж байна. Мөн энэ үйлдлийнхээ талаар тэрээр дараа нь хэвлэл мэдээлэл болон олон нийтийн сүлжээнд би хохь нь гэж хэлээгүй, зүгээр л чанга ярьсан гэх мэт бодит бус мэдээлэл хийж, “хулгайч айж байна” гэх ёс зүйгүй үг хэлсэн тул олон нийтийн өмнө уучлалт гуйх ёстой гэж үзэж байна гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн өгсөн тайлбартаа хувь хүнийхээ хувьд бүлгийнхээ чат групп дээр уучлалт гуйсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүний хувьд ардчиллын мэтгэлцээний зарчмаар явсан. Эрүүл мэндийн даатгалын сангийн ноцтой асуудлын талаар бухимдал, бухимдан чанга дуугаар ярьснаа хүлээн зөвшөөрч байна. Хохь чинь шүү, аятайхан байгаарай гэж хэлсэн нь Д.Ганмаа гишүүнд бус Г.Лувсанжамц гишүүнд хандаж хэлсэн юм. Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа буруу ойлгосон байна. Бухимдан ярьсандаа уучлал илэрхийлсэн бөгөөд уг асуудлыг олон нийтэд дэлгэх нь парламентын нэр хүндэд сөрөг нөлөөтэй гэж үзэж байна гэсэн тайлбар тус тус өгсөн болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа уг гомдлыг шийдвэрлэхдээ Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Ж.Галбадрах нараас гэрчийн мэдүүлэг авах, холбогдох Байнгын хорооны хуралдааны бичлэгийг хуулбарлан авах зэрэг хуульд заасан холбогдох нотлох ажиллагааг явуулах, өөрийн биеэр оролцож тайлбар хариу өгөх эрхийг хангаж ажиллахыг хүссэн хүсэлтийн дагуу Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцаас гэрчийн мэдүүлэг авлаа. Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцын өгсөн мэдээллийн хүрээнд Өргөдлийн байнгын хорооны хуралдааны үеэр Д.Ганмаа гишүүн эрүүл мэндийн салбарын мэргэжлийн зарчмын шаардлагыг тавьж байсан. Уг асуудалтай холбоотой асуулт, хариулт дуусаад,

миний хувьд үгээ хэлэхээр нэрээ өгчихсөн байсан. Тэгээд үгээ хэлээд сууж байтал Ж.Чинбүрэн сайд эсрэг талын ширээнээс тойрч ирээд, Д.Ганмаа гишүүний цаад талд сууж, ирж суугаад юм ярьж байсан. Д.Ганмаа гишүүнд хандан аятайхан байгаарай чи, хохь чинь шүү, юмаа унш, юм хумаа уншаарай гэсэн зандарсан өнгө аястай аясаар хэлэх нь сонсогдсон. Эмэгтэй хүнтэй ингэж харьцаж байгаа нь зохисгүй гэж бодсон учраас үгээ хэлж дуусаад, Ж.Чинбүрэн сайд дээр очиж та одоо яагаад байгаа юм бэ, хурал үймүүлээд байгаа юм уу, эмэгтэй хүнтэй яаж харьцаж байгаа юм бэ гэсэн чинь чи юу гээд байгаа юм бэ гээд над руу бас зандарсан ч, дараа нь тайвширч Д.Ганмаа гишүүнтэй ярилцаж байгаад, гарч явсан. Сайд тухайн үгийг надад зориулж хэлээгүй, Д.Ганмаа гишүүнд хандаж хэлсэн. Тухайн үг, үйлдэл нь энгийн мэтгэлцээнээс давсан үйлдэл байсан гэж тайлбар өгсөн байна.

Иймд ажлын хэсэг дээрх асуудлыг судлан үзэж, Монгол Улсын Их Хурлын гишүүн Ёс зүйн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.5-д биеэ авч явах, шударга байдлаар үлгэр дуурайл үзүүлэх, 2.2.1-д гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ баримтлах ёс зүйн шаардлага биелүүлэх, 3 дугаар зүйлийн 3.2-т бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн хүндэтгэлтэй хандаж, бусдыг гэмт хэрэгт холбогдуулан гүтгэн доромжлохыг цээрлэнэ, 3.5-д чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны дэг зөрчиж, хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, хуралдаанд үг хэлэх, байр сууриа илэрхийлэхдээ бүдүүлэг үг хэлэх, хэллэг хэрэглэх, бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжлохыг хориглоно, 3.17-д Төрийн ёслол хүндэтгэлийн болон Төрийн ордны дэг журмыг чанд баримтлахаас гадна Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааны танхимд биеэ зөв авч явах үүрэгтэй ба бусдыг ялгаварлан гадуурхах зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэж байгаа тул Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд, Ёс зүйн дэд ба бусдын хяналт, энд алдаад дутуу биччихсэн байх юм. Ёс зүйн дэд хорооны юм болов уу, бусдыг ялгаварлан гадуурхах зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно гэсэн ёс зүйн дэг ба бусдыг ялгаварлан гадуурхах зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж үзэж байгаа тул Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны хуралдаанд оролцож, хэлэлцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.1.2-т заасны дагуу уучлалт гуйхыг үүрэг болгох сахилгын хариуцлага ногдуулах нь зүйтэй гэсэн санал Монгол Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хорооны хуралдаанд оруулж байна. Иймд ажлын хэсгийн саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Энд алдаатай бичсэн байна.

**Б.Баярбаатар:** Ажлын хэсгийн гишүүн Номин танд баярлалаа. Ажлын хэсгийн дүгнэлттэй холбоотойгоор асуулт асуух гишүүд байна уу? Болно. Энхтуяа гишүүн, Чинбүрэн гишүүн, кнопоо даръя. Чинбүрэн гишүүнээр тасаллаа. Энхтуяа гишүүн.

**Д.Энхтуяа:** Надад бол асуулт алга. Би нэг үг хэлье гэж бодож байна. Яах вэ энэ юутай холбоотой өргөдөл гомдол ирээд, тэгээд Ёс зүйн дэд хороо хэлэлцэж, хэлэлцэх ёстой байх л даа одоо хууль, дүрэм журмынхаа дагуу. Гэхдээ бол яах вэ яг энэ дээр бол яг ямар шийдвэр гарахыг бол би мэдэхгүй байна. Ер нь бол яах вэ парламентын хэлэлцүүлгийн үед янз бүрийн л асуудал болдог. Тэгэхээр ийм хоорондын маргаан юм уу гэж миний хувьд харсан.

Яг одоо Ёс зүйн дэд хороо Улсын Их Хурлын ёс зүйн код, ёс зүйн зарчим яривал бид бол арай өөр юм яриад сууж байх ёстой гэж би бодож байгаа байхгүй

юу. Өнөөдөр нэг ийм юм яриад, тэгээд тэрэн дээр нэг шийдвэр гаргаад, энэ дээр бол би бол түдгэлзэж байна. Ямар нэгэн санал бол өгөх надад тийм шаардлага байхгүй гэж би бодож байна. Ажлын хэсэг, дэд ажлын хэсэг дээр бол Чинбүрэн гишүүн бол Ганмаа гишүүнээс уучлалт гуйж, цэцэг явуулсан гэж ингэж хэлсэн. Тэгээд учраа олчих биз дээ гэж бодож байна.

Ёс зүй одоо яривал би бас нэг зүйл хэлье гэж бодож байна л даа. Дөнгөж саяхан л болоод өнгөрлөө. Засгийн газрыг огцруулах энэ санал дээр Байнгын хороон дээр Засгийн газрыг огцруулах гарын үсэг зурсан гишүүд орж ирээд Засгийн газрыг огцруулахгүй гээд ингээд санал өгөөд гарсан. Би бол бодохдоо Засгийн газрыг огцруулахаа больж байгаа юм байна гэж ингэж бодсон. Гэтэл Их Хурлын чуулган дээр орж ирээд, ирцэд орсон гишүүд гараад явсан байсан, эзэнгүй байсан ч гэсэн санал нь одоо унахаар ингэж томьёолоод ингээд орж ирж байгаа чинь ёс зүй алдсан энэ асуудлыг бид харин ёстой жинхэнэ ярилцах ёстой юм биш үү? Би бол жишээлбэл 18 цаг болоод ажил тараад явсан, 18 цагаас хойш л залгасан, янз бүрийн мессежүүд ирж байсан. Монгол төрийн нэг ёс жаяг, ёс журам гэж бид бас байдаг. Бид энэ Монгол төрийг түшилцэж байгаа төрийг нь түшээд байна. Шөнийн их муу цаг, чононы гүйдэлтэй цаг л гэж ярьдаг дээдсүүд, дээд өвгөд. 3, 4, 2, 3, 4, 5, 6 цаг хүртэл мессеж бичиж ингэж ярьж байгаа. Тэгэхээр энэ чинь одоо яг Их Хурлын Хурлын гишүүний ёс зүйн асуудал биш юм уу? Энийг бид харин ярилцах ёстой юм биш үү? Би бол тэгж бодож байна.

Тэгээд энэ дээр бол саяын энэ 2 асуудал дээр би бол түдгэлзэж байна. Тэгээд хоорондоо учраа олоод, заавал тэгээд нэгнийгээ ингээд л нэг олон нийтийн юугаар уучлалт гуй гээд л ингээд, хоорондоо ярилцаад л нэг нь уучлаарай гээд цэцэг өгөөд л ингээд салсан л юм байна лээ шүү дээ тийм ээ. Тэгэхээр энэ асуудлыг одоо яриад сууж байгаа нь үнэндээ надад инээдтэй санагдаж байна. Тэгэхээр яг ёс зүйн код ярих гээд байгаа юм бол Ёс зүйн дэд хороо ёс зүй, зарчим ярих гээд байгаа юм бол тэр эсрэг санал өгчхөөд, дахиад Засгийн газраа огцруулна гээд ингээд явна. Тэгэхээр санал нь бол өөрчлөгдсөн гэж би бол итгэж байсан. Гэтэл бол тэгээгүй юм шиг байгаа юм. Дахиад энэ Монгол төрийн Засгийн газрыгаа огцруулна гээд байх шиг байгаа юм. Тэгсэн хэр нь эсрэг санал огцруулахгүй гээд ингээд санал өгөөд, энэ чинь ёс зүйн зөрчил биш юм уу? Би бол ийм л бодолтой байна. Энэ ёс зүй ярих гэж байгаа бол гишүүд өөрсдөөсөө.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын гишүүн чуулганы нэгдсэн хуралдааны танхимд хэлсэн үг, өгсөн саналдаа хариуцлага хүлээдэггүй гэсэн хуультай. Өнөөдөр парламент ард түмний төлөөлөл, ард түмний саналыг авч бүрдэж, энэ парламентыг бүрдүүлж ажиллаж байгаагийнхаа хувьд мандат төлөөлж байгаа учраас тэр мандатаа төлөөлж тэр хүн асуулт асууж, үг хэлж, саналаа өгөх асуудал нь бол нээлттэй байдаг гэдгийг бас танд хэлье.

Ер нь сүүлийн үед эмэгтэйчүүдээс илүүтэйгээр энэ Ёс зүйн дэд хороонд гомдол, санал өгч байгаа. Хувь хүний хоорондын харилцааны асуудлаас үүдэлтэй байгаа байх. Мэдээж энэ парламент бие биедээ их хүндэтгэлтэй хандах ёстой. Мэтгэлцэх зарчим байж болно, хоорондоо үзэл бодол, үг хэл зөрөх зүйл байж болно. Тэгэхдээ доромжийн үгийг бол бие биедээ хэлэх нь бол энэ ёс суртахуун, хувь хүний ёс суртахуунд бол нийцэхгүй болов уу гэж би хувь хүнийхээ хувьд боддог юм.

Сүүлийн үед энэ парламентад бие биеийгээ элдэв долоогоор хэлэх, янз бүрийн гэмт хэрэгт гүтгэх, доромжийн үгээр бие бие рүүгээ орилж хашхирах бол одоо ер нь энгийн үзэгдэл мэт болсон. Өнөөдөр бид энэ сонгосон иргэд, сонгогчид

өөрсдөө биднийг энэ хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан харж байгаа. Өнөөдөр ёс зүйн асуудлыг улс төржүүлж болохгүй. Улс төржүүлж болохгүй. Тэр тусмаа хуульд тодорхой заачихсан асуудлаар улс төржүүлээд явах нь өөрөө зөв юм уу. Хэрвээ үнэхээр тэр ёс зүйн асуудал гэж үзэж байгаа бол тодорхой хуульд нь өөрчлөлтийг нь оруулсны дараа энийг бол ёс зүйн асуудал гэж хэлэлцэх нь зөв. Ер нь бол 2 хүний хоорондын маргааны асуудал дээр аль болох энэ Дэд хороо руу татаж авчрахгүйгээр асуудлаа шийдвэрлэх нь тэр тусмаа өнөөдөр Улсын Их Хуралд мандат төлөөлөөд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүний хувьд бол ухамсрын түвшиндээ бол энэ асуудлуудаа бол шийдвэрлэх ийм боломжтой гэж бол Дэд хорооны даргын хувьд бол харж байгаа гэдгийг би бас хэлье. Чинбүрэн гишүүн асуултаа асуучих. Дараа нь Ганмаа гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Болсон процесс бол ярилаа. Тэгээд юуны Галбадрах гишүүнээс бас гэрчийн мэдүүлэг авлаа гэсэн тайлбарыг нь би сонсоогүй өнгөрчхөв үү, уншсан юун дотор? Галбадрах гишүүнээс. Нөгөө бичлэг энэ тэр татаж авах ёстой гэсэн гэдэг нь тэр нь татаж авсан болов уу? Яагаад гэхлээр нөгөө бухимдалтай олон улсууд чинь хоорондоо нэг чанга дуугаар баахан юм ярьчихлаар тэр нь чи ингэж хэлсэн, чи ингэж хэлээгүй гээд тийм дундын яриа болоод байх юм. Уг нь баримттай юм байвал, уучлаарай би нөгөө яачхаад чанга ярьж чадахгүй байгаад байгаа юм. Тэгэхлээр ийм баримттай, нотолгоотой юмнуудаараа тавьчихвал амар юм шиг санагдаад байгаа юм. Тэгээд яах вэ би бас хэлснээ дахиад давтаад хэлэхэд бухимдаад чанга ярьчихсан, тэрийгээ хүлээн зөвшөөрч байгаа.

Тэгээд намайг Ганмаа гишүүн наашаа суугаад тэгвэл ярьчихъя гээд, тэгээд би хажууд нь ирээд суусан нь үнэн. Тэгээд суугаад яриад, чанга ярихлаар Лувсанжамц гишүүн та яагаад эмэгтэй хүн рүү чанга яриад байгаа юм бэ гэхэд нь би нэг бухимдаад босоод, тэгээд аятайхан байгаарай гэдэг үг хэлсэн нь үнэн. Би тэрийг хүлээн зөвшөөрөөд байгаа шүү дээ. Тэгээд уг нь бол Ганмаа гишүүн рүү хаяглаж хэлээгүй л юм сан уг нь. Тэгээд тэрийг үгүй, заавал над руу хэлсэн гээд байгаа юм. Тэгэхлээр бодитой бичлэгийг нь гаргаад харуулчихвал яадаг юм бол, тийм боломж байгаа юу? Тийм юм хийсэн болов уу, үгүй болов уу? Тэгээд уучлалтаа гуйчихъя. Надад энэ дээр бол нэг их тийм бие биетэйгээ муудалцаад, хувь хүний харьцаа байгаа биш, ажил төрлийн холбоотой л юм болсон учраас уучлал гуйхад бэлэн байгаа гэдгээ бас илэрхийлсэн.

**Б.Баярбаатар:** Ганмаа гишүүн.

**Ж.Чинбүрэн:** Хариултаа авч болох уу?

**Б.Баярбаатар:** Би бичлэг хэлчихлээ.

**Д.Ганмаа:** Чинбүрэн гишүүнд баярлалаа. Юуны өмнө гараа гэмтээчихсэн явж байгаа юм байна. Эмч хүний хувьд, эмэгтэй хүний хувьд бас ...sorry. Тэгээд бие нь муу байхад, тэгэхдээ болсон процесс болсон л юм чинь болсноороо л ярья.

Би, 1 дүгээрт улс төр энэ Энхтуяа гишүүн хаачив? Улс төртэй бол энэ тас хамаагүй асуудал. Засгийн газар огцруулахтай бүүр ч хамаагүй асуудал. Яагаад гэхээр энэ асуудал яг болсон юм нь бол 9 сарын 30. 9 сарын 30-нд юу болсон бэ гэхээр Өргөдлийн байнгын хороогоор асуудал орж ирсэн, асуудал орж ирэхдээ эмч, эмнэлгийн ажилчдын цалинг нэмэх асуудал байсан. Номин гэдэг гишүүн 18 наснаас 81 настай хүн, дундаж нас нь 35 насны бараг хотын Монгол Улсын бүх төлөөлөл байсан. Энэ төлөөллийн дагуу өргөдөл орж ирээд, тэр өргөдлийн дагуу цалин

мөнгийг нэмэх талаар би одоо шийдвэртэй, шийдэлтэй мэдээлэл дээр суурилсан үгээ хэлсэн. Юу гэсэн үг вэ гэхээр тэгээд тэрэнтэй холбоотой асуултуудыг сайдаас асуусан. Салбарын сайд л мэдэх мэдээлэл учраас надад байхгүй мэдээллүүд байсан. Цалингийн голчийг асуусан, хувийг асуусан. Цалин нэмэхийн тулд үр ашиг заавал явах ёстой нэмэлтээр, хулгайн асуудлыг би тухайн үед бол ярихгүй гэж хэлсэн. Яагаад гэхээр энэ бол бүүр тусдаа асуудал, прокурор, цагдаа сэргийлэх болоод явчихдаг учраас. Ийм асуудлуудыг ярьсан бид хэд. Асуулт асуусан, саналаа хэлсэн.

Сая магадгүй ямар нэгэн байдлаар энэ чинь нэг л засагтай холбоотой юм болоод л явчихсан. Тийм ойлголттой хүн орж ирсэн юм шиг байна, Энхтуяа гишүүн. Уул нь асуулт асуугаад, болсон процессыг ярьж байхад эхлээд ажлын хэсэг гээд 3 хүн томилчихсон байсан шүү дээ. Нэг нь Номин сайд сууж байна хажууд, Энхтуяа, тэгээд Саранчулуун гишүүн 3 байсан. Би 3-ын 3 эмэгтэй хүн, ядаж 1 эрэгтэй хүн байвал зүгээр юм даа гэж бодож байсан юм тухайн үед. Яагаад гэхээр дандаа нөгөө эмэгтэй хүн эмэгтэй хүнээ юу яагаад ч байгаа юм шиг, эмэгтэй хүн талаас харчих вий дээ гээд. Энд бас эмэгтэй хүнтэй хамааралтай асуудал ерөөсөө байхгүй.

3 дугаарт энэ бас хулгайтай холбоотой асуудал юу ч байхгүй. Надад өмнө нь байсан тэр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын Энхболд билүү тэр хүнийг би танихгүй. Ажлаар буюу энэ чуулганаар хэлэлцээрээр л ярьж байсан. Хулгай зэлгий байдаг бол тэд нарыг өмөөрөх ямар ч боломж байхгүй. Тэр асуудлаа ч гэсэн би Чинбүрэн гишүүнд удаа дараа хэлж байгаа.

Мэтгэлцээн гээд байгаа юм. Мэтгэлцээн бас тас байгаагүй тэнд. Мэтгэлцээнийг би насаараа мэтгэлцээн хийж байгаа. Монгол байтугай хүний нутагт би 20 жил Харвардын Associate Professorship гэдэг бол захын хүн олчихдог ч ажил биш, насаараа мэтгэлцэж амьдарч байгаа. Тэгээд нэг захаасаа ирчихсэн нэг Ази гэдгээрээ янз янзаар би бас хэлүүлж ч үзэж байсан. Тэгэхдээ Монгол Улсад ирээд зүгээр болсон ёс зүйн асуудлыг энийг нь улс төр ч юм шиг, хулгай ч юм шиг.../минут дуусав/

**Б.Баярбаатар:** 2 минут сунгачихъя.

**Д.Ганмаа:** Ийм байдлаар танилцуулаад, ойлгуулаад, тийшээгээ асуудлыг шийдэх гээд, санал ярихдаа ч гэсэн энэ нь нэг инээдэм ханиадам байдлаар яваад байгаад би үнэн голоосоо сэтгэл зовниж байна. Энэ бол парламент, парламент, засаг хоёрын харьцаа, сайд Улсын Их Хурлын дараагийн ажлууд, мэтгэлцээн, асуултад асуух, хариу өгөх, дараа дараагийн олон юманд энэ чинь нэг бодлын жишиг, нэг бодлын нэг л кейс болж явах юм. Тэгэхлээр зэрэг би зүгээр нэг их уучлалт аймаар гуйлгачих гээд байгаадаа ч асуудал биш. Чинбүрэн гишүүн чатаар яах аргагүй бичсэн байна. Тэр дунджийг бичихдээ, энийг ч гэсэн би авлаа. Зүгээр 10 сарын 01 миний төрсөн өдөр болж таарсан, маш олон хүнд цэцэг өгсөн юм, их баярлаж байгаа цэцэг өгсөн хүмүүстээ. Цэцгээс гадна бэлгүүд ч авсан, тэрэнтэй холбоотой бас юм яригдсан юм шиг байна.

Тэгэхдээ энэ дээр бол Чинбүрэн гишүүн өөрөө ч хэлээд байна шүү дээ. 1 дүгээрт тэр юуг нь татаад харчхаач дээ, би бас тэнэг хүн биш, хүн чанга ярьж байна уу, дайрч байна уу, заналхийлж байна уу ялгаж чадна. Дээрээс нь би худлаа ярьдаг хүн биш.

**Б.Баярбаатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Бичлэг бол байгаа юм байна. Үг хэлнэ, тийм үг хэлнэ. Би зүгээр дунд нь нэг Дэд хорооны даргын хувьд нэг санал тавимаар байна. 1 дүгээрт өнөөдөр гомдол гаргасан Улсын Их Хурлын гишүүн, хариуцлага хүлээх гэж байгаа Улсын Их Хурлын гишүүн аль аль нь л нэг улс төрийн намаас нэр дэвшиж орж ирсэн улсууд. Мэдлэг, боловсрол, туршлага, улс төрийн хувьд хэн хэн нь өндөр дээгүүр түвшний улсууд. Мэдээж тухайн үедээ алдаа дутагдал гарсан байх гэж үзэж байна. Би зүгээр Чинбүрэн гишүүнд нэг санал тавих гэсэн юм. Та албан бланк дээрээ Улсын Их Хурлын гишүүн Ганмаа гишүүнд хандаад уучлал хүссэн энэ нэг албан тоот явуулах боломж байгаа юу? Тэрийг нь Ганмаа гишүүн та хүлээж авах боломжтой юу?

Хэрвээ би тийм бол өнөөдөр би энэ асуудлыг хаагаад, заавал Ёс зүйн дэд хорооноос тогтоол гаргамааргүй байна гэдэг ийм саналыг тавих гэсэн юм. Одоо хоёр хүн хоёулаа сууж байгаа учраас. Би сая энэ бодит юунаас нэг Алтангэрэл гишүүн, Оюунсайханы Алтангэрэл гишүүн ахлаад, энэ рекорд.мн сайтаас гомдол ирсэн юм. Энэ нөгөө Дэлгэрсайхан сайдтай холбоотой гомдол ирээд, тэгээд энэ Дэлгэрсайхан сайдын яг өөрийнхөө бланк дээрээ бичээд, рекорд.мн сайтын хамт олноос ингээд уучлал хүсчхэж байгаа юм. Тэгэнгүүт нөгөө сайтын хамт олон гомдол тайлагдлаа гээд ингээд өнөөдрийн хурлаар хэлэлцэх ёстой асуудлаас энэ асуудал хасагдаад ингээд, зүгээр танилцуулагдаарай гэсэн учраас би бас ингээд танилцуулах нь зөв болов уу гэсэн ийм бодолтой байна.

Хэрвээ энэ тал дээр та 2 маань хүлээн зөвшөөрвөл би асуудлыг энд нь ингээд цэг тавья, зөвшөөрөхгүй гэсэн тохиолдолд бол тэгээд тогтоол батлагдаад явахаас өөр аргагүй нөхцөл байдал руу орно гэдэг би саналыг хэлье. Үг хэлэх гишүүд нэрс өгье? Алтангэрэл гишүүнээр тасаллаа. Бадарчийн Хэрлэн гишүүн.

**Б.Хэрлэн:** Тэгэхээр өнөөдөр бид миний бодлоор энэ 2 хүний хоорондын харилцааны асуудал хоорондоо яриад учир зүйгээ олоод болчхоогүй юм уу? Чинбүрэн гишүүн уучлалт гуйчихсан юм байна, бүүр цэцэг өгөөд явуулчихсан юм байна, сая хурал дээр бас сая уучлаарай гээд хэлчихлээ. Заавал тэр албан бланк дээр бичиж, тийм баримтжуулж байгаа юм шиг юм үлдээгээд л ингээд ийм ялих ялихгүй юмыг чинь бүүр нэг ийм бүүр их тийм ач холбогдол өгөөд аймаар том болгоод байх хэрэг байгаад байгаа юм уу? Бид сая хэллээ шүү дээ. Хуралдааны танхимд хэлсэн үг, өгсөн саналынхаа төлөө Улсын Их Хурлын гишүүд хуулиар нэг их хариуцлага хүлээгээд байдаггүй гээд сая Баярбаатар дарга хэлж байна л даа. Хуралдаан дээр бид үг сөрөх, бие биеийнхээ сэтгэлд бас юм хийх тиймэрхүү үйлдлүүд гарч л байдаг.

Саяын Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр би тухайлбал Ариунзаяа гишүүн бид хоёрын хооронд бол нэлээн ширүүхэн юм болоод л авсан. Тэгсэн харин Ариунзаяа маань цүнхнээсээ чихэр гаргаад тэгээд л хоёулаа чихэр хувааж идээд л, тэгээд л бие биеийгээ уучлаад, зүгээр болоод л яваад өгсөн. Үгүй ээ одоо энэ чинь яг ажил яриад, ажилдаа шатаад ингээд явж байх үед хааяа заримдаа сэтгэлийнхээ хөдлөлийг барьж дийлэхгүй уурлах бухимдах юмнууд бол гардаг л даа. Тэгэхээр энэ дээр нэг жаахан одоо энэнээс илүү чухал асуудлууд бидэнд зөндөө байна шүү дээ. Заавал тэгээд албан бланк дээр бичээд л, заавал тэгээд баримтжуулаад л тэгээд байх хэрэг юу байсан юм. Уучлалаа гуйлаа, цэцгээ өглөө, 2 ч, 3 ч хэллээ, болоо юм биш үү? Би бол тэгж бодож байна.

**Б.Баярбаатар:** Алтангэрэл гишүүн.

**О.Алтангэрэл:** Би яах вэ яг энэ маргаантай, яригдаж байгаа асуудалтай шууд хамааралгүй боловч хэдүүлээ нэг зүйлийг бодох ёстой юм байна гэж бодож байгаа. Ер нь бол Байнгын хорооны хурлын үеэр, чуулганы хуралдааны үеэр гишүүд хоорондоо маргалдах ийм зүйлүүд гарч байгаа. Тэгээд бид бас алдаа гаргаж байна. Бусадтайгаа заримдаа хэдий адилхан Их Хурлын гишүүн ч гэсэн зохисгүй харьцаж байна. Миний хувьд ч гэсэн яг энэ сургамжтай одоо яг энэ хурал дээр суугаад явахад ч гэсэн зарим нэг хүнтэй муудалцахад ширүүн дориун үг хэрэглэсэн, бухимдсан ийм байдал бас гаргадаг юм байна даа гэж бодож байна.

Тэгэхээр ер нь энэ асуудал бол зөвхөн манай 2 гишүүний хоорондын асуудал биш, аль алиных нь тэр гомдол гаргах болон тайлбар тавих тийм субъектив эрхийн асуудлыг бид бол нэг их айхтар хөндөөд хэрэггүй байх. Гомдол гаргах ч эрхтэй, нөгөө талаасаа өөрийнхөө асуудал дээр шалгуулж, тайлбар өгөх ч эрхтэй. Тэгэхээр энэ асуудал маань бас яг ингээд цааш цаашдаа гишүүдийн дунд асуудал үүсэх, ингээд ирээдүйд гарч болох маргаан мэтгэлцээнийг шийдвэрлэх, түүнд Улсын Их Хурал, нэн ялангуяа Улсын Их Хурлын бүтцийн байгууллага Байнгын хороо, Байнгын хорооны бүрэлдэхүүнд байгаа Дэд хороо, тухайлбал Ёс зүйн дэд хороо цаашдаа ямар байдлаар асуудалд хандах юм, яаж шийдвэрлэх юм гэдэг дээр жишиг болж байгаа учраас бүгдээрээ энэ дээр цаашдаа жишиг болоод үлдчих, хууль, эрх зүйн хувьд маргаан гарахгүй байх энэ чиглэлээр анхаарах нь зүйтэй байх.

Тэр ер нь материал бүрдүүлэлтийн хувьд ч гэсэн бас нэгэнтээ хуралдааны үеэр бичлэгтэй, баримттай зүйл байгаа учраас тэнд нь архивлаж бичиж үлдээх, асуудал яаж шийдэгдэв гэдгээ сайн материалжуулж үлдээх ийм шаардлага байгаа байх. Яагаад гэвэл энэ бол зөвхөн өнөөдрийн манай 2 гишүүний хоорондох асуудал биш, цаашдаа бид их олон удаа ярилцаж магадгүй, жишиг тогтоож болзошгүй асуудал гэдгээр нь гишүүд маань асуудалд хандах нь зүйтэй гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

**Б.Баярбаатар:** Номин гишүүн тайлбар хийчихье.

**Ч.Номин:** Би ажлын хэсэгт орж ажилласан хүнийхээ хувьд хэлье. Тэгээд яах вэ мэдээж энэ бол ингээд хувь хүмүүсийн хоорондох асуудал. Тэгээд би түрүүн Алтангэрэл сайдын хэлсэнтэй санал нэг байна. Хүмүүсийн гомдол гаргах эрх, дээрээс нь цаашлаад хариулт өгөх, тайлбар тавих эрхэд нь бид халдаад дэмий байх. Гэхдээ ер нь бол аливаа зүйл дээр бид бас цаашдаа ямар нэгэн ийм прецедент үүсгэхгүй байх дээр анхаарах нь зүйтэй болов уу. Ер нь бол улс төрд байж байгаа тохиолдолд мэдээж өндөр дуугаа өргөөд мэтгэлцэх зүйлүүд бол гардаг. Гэхдээ энэ дунд бол аливаа хүнийг одоо дарамтлуулсан, цаашлаад өөрийнх нь нэр хүндэд халдсан ийм мэдрэмжийг бол төрүүлэхгүй байх ёстой гэж харж байна.

Бидний хувьд бол уулзсан хүмүүсээс үзэхэд бол Лувсанжамц гишүүний хувьд бол ийм тэр хүний хажууд нь байсан мэдрэмж нь тийм байсан гэдэг зүйлийг хэлсэн. Тэгэхээр одоо хэн нэгэн хүнийг шүүгээд байхдаа гол нь биш, гол нь өнөөдөр бол бид энэ цааш цаашдаа ийм мэтгэлцээн гэдэг нэрийн доор хэн нэгэн хүнийг өөрөө тэр, өөрийнхөө эрх, дээрээс нь өөрийнхөө хэлэх үг хэлэх эрхдээ халдуулж байна гэдэг ийм мэдрэмжийг төрүүлэхгүй байх нь чухал болов уу гэж бодож байна. Тэгээд сүүлийн үед бол бас чуулганы танхимд олон гишүүдийг янз бүрээр хэлж, бүүр хамгийн сүүлд энэ чинь хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүртэл гарч ирж жагсах хэмжээнд хүртэл болж байгаа. Тэгэхээр энэ бол нэг ийм цаашдаа ёс зүйтэй, хэлж ярьж байгаадаа бусдадаа хүндэтгэлтэй хандах ёстой, аливаа үгийг зөв зохистой хэрэглэх ёстой гэдгийг бид гишүүд өөрсдөө бодож тунгааж явах ёстой зүйл гарч ирж

байна уу гэдгийг бид бас бодолцох ёстой болов уу. Түүнээс биш өнөөдөр бид бүхэн нэг юм шүүх гээд ч юм уу, хэн нэгэн хүнийг ялтан хэрэгтэн болгох гээд ч юм уу, хэн нэгэн хүнд алдар цол өгөх гээд байгаа зүйлдээ биш болов уу гэж бодож байна.

**Б.Баярбаатар:** Ганмаа гишүүн.

**Д.Ганмаа:** Микрофонгүй ч ярьчихсан яах вэ дээ.

**Б.Баярбаатар:** Микрофонтой ярьчих, протоколд үлдэх учраас.

**Д.Ганмаа:** Одоо ингээд л үгээ хэлчхэнгүүтээ, миний үгийг сонсохгүй гарч яваад байгаа болохоор би одоо хариулах гээд хариулж болохгүй, байхаар байж болохгүй. Тэгэхдээ яах вэ Чинбүрэн гишүүн бид хоёрын хувьд бол Чинбүрэн гишүүн өөрөө юу яачихъя, юу гэлээ сая тэр, тийм бланк дээр бичиг гаргаад, уучлалт гуйчихъя гэж байна. Би тэрийг бол хүлээж авахад бэлэн байна.

Гол санаа нь миний бодлоор ер нь яг болсон процесс дээр ингээд 2 тэс өөр ойлголт яваад, мэдээж хажууд нь байгаагүй хүмүүс юм чинь ямар ч ойлголтгүй байгаа. Надад байгаа мэдрэмж одоо сар гаруй болчхож байгаа болохоор би бас гайгүй ер нь бол бараг мартагнаж байна л даа. Тийм. Тэгээд, уужрахаасаа гадна, мартагнаж байна. Гол санаа нь Чинбүрэн гишүүн одоо нөгөө над руу хохино шүү гэж хэлээгүй, аятайхан байгаарай гэж хэлээгүй, би зүгээр чанга дуугаар ярьсан, мэтгэлцээн байсан гээд давтагдаад байгаа нь надад аягүй ёс зүйн хувьд үнэхээр асуудалтай санагдаад байгаа байхгүй юу. Яг надад болсон тохиолдол яг л болсон юм нь энэ, бичлэг нь байгаад байгаа. Та хэд авч болохгүй бол надад тэр бичлэг нь байна. Тэгээд босож ирээд эрэгтэй хүн над дээр ингэж биеэрээ нөмөрч зогсож байгаад, ингээд хэлээд байхаар би “та хажууд суугаад байх” гэж хэлж, суулгасан. Түүнээс биш Лувсанжамцыг бол хохино шүү, аятайхан бэ гэж хэлээгүй. Лувсанжамц бүүр Япон сургуультай хүн болохоор л тэсээгүй байх гэж бодсон. Галбадрах багш байсан, Мөнхбаясгалан гишүүн энэ тэр болохоор нөгөө нам болохоор ийшээ нэг их оролцъё гэж бодохгүй байгаа байх л гэж би бодож байна.

**Б.Баярбаатар:** Тэгвэл Чинбүрэн гишүүн түрүүн бол миний тавьсан саналыг хүлээн зөвшөөрсөн. Сая Ганмаа гишүүн бол албан ёсоор протоколд тусгаад, ингээд хүлээн зөвшөөрчхөж байгаа учраас энэ асуудлыг энүүгээр нь ингээд дуусгая тэгэх үү? Би заавал өнөөдөр Дэд хорооноос тогтоол баталж, асуудал яримааргүй байна. Тийм учраас ингээд та 2 маань бие биетэйгээ сайхан ойлголцоод, ингээд яв.

Манай зарим Ёс зүйн хорооны гишүүд маань одоо бас асуудалд хувийн байр сууриас хандаж ингэж явж байгаа нь бол өнөөдрийн хурлаар ажиглагдлаа. Бид ийм байр суурьтай бол байж болохгүй. Өнөөдөр энэ хэдий 2 хүний хоорондын маргаан байсан ч гэсэн энэ нийгмийн харилцаа шүү. Бие биедээ хүндэтгэлтэй хандах харилцааны асуудал. Бид өнөөдөр Монгол Улсын 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэд. Бас хэлэх үг, санаа бодлоо зөв илэрхийлэх тал дээр өөрийгөө зөв зүйтэй талаас нь ойлгуулах, ухамсарлах ийм ухамсартай иргэд гэж ойлгож байгаа шүү. Тийм учраас цааш цаашдаа энэ хэдий өнөөдөр энэ улс төрийн нөхцөл байдлаас болоод уурлаж болно, бухимдаж болно, энийгээ буруу аргаар илэрхийлэх нь өөрөө бол буруу юм гэдгийг хэлээд, асуудлыг өнөөдөр ингээд хаая.

Хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хурлыг хаасныг мэдэгдье.  
Хуралд оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА